



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.5, 8.4.7 дахь заалт, 8.6 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар бүлгийн 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрт магадлан шинжилгээ хийхэд шинжээчид тавих үндсэн шаардлагыг хангасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох харилцааг зохицуулах “Шинжээчийг сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Шаардлага хангасан шинжээчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, сургалтад хамруулан эрх олгох, ажиллуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд дээрх журмыг мөрдөн, хэрэгжүүлж ажиллахыг Магадлан итгэмжлэлийн нэгж (Б.Мядагмаа)-д даалгасугай.

3.Эрх бүхий шинжээчийг нөөцийн бүртгэлд бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэхийг Хүний нөөц, хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Тэргэл), Мэдээллийн технологи хариуцсан шинжээч (Ц.Ёндонсамбуу) нарт үүрэг болгосугай.

4.Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны тайлан, мэдээллийг хүлээн авч, үр дүнд нь дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хянаж ажиллахыг Дотоод аудит, чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан шинжээч (Б.Соёлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.АРИУНБОЛД

Боловсролын магадлан итгэмжлэх
үндэсний зөвлөлийн Ажлын албаны
захирлын 2023 оны 02 дугаар сарын
06-ны өдрийн Атоот тушаалын нэгдүгээр
хавсралт



ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл/цаашид "БМИҮЗ" гэх/-ийн шаардлага хангасан шинжээчид боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх эрх олгох, сунгах, хүчингүй болгох, шинжээчийг сонгон ажиллуулахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. БМИҮЗ-ийн шинжээчид тавих шаардлага

Шинжээчид нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.Боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагаас шинжээчид нэр дэвшигч:

2.1.1.Дээд боловсролын сургалтын байгууллагад шинжээчээр ажиллах иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.1.Докторын зэрэгтэй эсвэл тухайн чиглэлээр мэргэшлийн зэрэгтэй байх;

2.1.1.2.Дээд боловсролын сургалтын байгууллага эсвэл эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.1.3.Судалгааны ажил хийж, ном товхимол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн байх;

2.1.1.4. Боловсрол судлал, сургалтын технологи, кредит систем, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитаар мэргэшсэн, гадаад болон дотоодод эдгээр чиглэлээр сургалт, семинарт хамрагдсан бол давуу тал болно;

2.1.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинжээчээр ажиллах иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.2.1.Магистр, түүнээс дээш боловсролын зэрэг эсвэл мэргэжлийн өндөр зэрэгтэй байх;

2.1.2.2.Журмын 2.1.1.2 заалтыг хангасан эсвэл мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.2.3.Судалгааны ажил хийж, ном товхимол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн байх;

2.1.2.4.Боловсрол судлал, чадамжид суурилсан сургалт, үнэлгээ, сургалтын технологи, хяналт-шинжилгээ, аудитын чиглэлээр гадаад

болон дотоодод сургалт, семинарт хамрагдаж байсан бол давуу тал болно;

2.1.3.Бага, дунд боловсролын сургалтын байгууллагад шинжээчээр ажиллах иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.3.1.Магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй;

2.1.3.2.Боловсролын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, боловсрол судлалаар мэргэшсэн байх;

2.1.3.3.Ерөнхий боловсролын сургуулийн багш бол “Тэргүүлэх багш”, түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх;

2.1.3.4.Судалгааны ажил хийж, ном товхимол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн байх;

2.2.Шинжээчид нэр дэвшигч ном зүйч нь шаардлагыг хангасан байна.

2.2.1.Бакалавраас дээш боловсролын зэрэгтэй;

2.2.2.Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын болон төрөлжсөн номын сангуудад 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.2.3.Мэргэжлээрээ ном, товхимол, гарын авлага хэвлүүлсэн байвал давуу тал болно;

2.3.Шинжээчид нэр дэвшигч санхүүч, нягтлан бодогч нь шаардлагыг хангасан байна.

2.3.1.Бакалавраас дээш боловсролын зэрэгтэй;

2.3.2.Мэргэшсэн нягтлан бодогч байх;

2.4.Шинжээчид нэр дэвшиж буй оюутан дараах шаардлагыг хангасан байна.

2.4.1.Сурлагын голч дүн нь 3.2-оос доошгүй байх;

2.4.2.Тухайн хөтөлбөрийнхөө үндсэн суралцагч байх;

2.4.3.Сургалтын болон хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулахад санал өгч оролцож байсан, санаачилгатай, идэвхтэй суралцагч бол давуу тал болно;

2.5.Аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагыг төлөөлөх иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

2.5.1.Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй эсвэл мэргэшлийн өндөр зэрэгтэй;

2.5.2.Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.5.3.Боловсрол судлал, мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил хийж, ном товхимол хэвлүүлсэн, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл нийтлүүлсэн байвал давуу тал болно;

2.5.4.Сургалтын технологи, кредит систем, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитаар мэргэшсэн, гадаад болон дотоодод эдгээр чиглэлээр сургалт, семинарт хамрагдсан байвал давуу тал болно;

2.6.Шинжээч нь дараах ур чадварыг эзэмшсэн байна.

2.6.1.Мэргэжлийн туршлага:

2.6.1.1.Мэргэжлийн чиглэлээр салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байх;

2.6.1.2.Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх чадвартай байх;

- 2.6.1.3. Үнэлгээний арга аргачлалаас оновчтойг нь сонгон ашиглах чадвартай байх;
- 2.6.2. Техник ажиллагааны ур чадвар:
 - 2.6.2.1. Үнэлгээний зорилго, зорилтыг тодорхойлох;
 - 2.6.2.2. Мэдээллийн эх сурвалж, нотлох баримттай ажиллах;
 - 2.6.2.3. Асуудлыг нарийвчлан тодруулах;
 - 2.6.2.4. Өгөгдөл, мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх;
 - 2.6.2.5. Баримт бичиг боловсруулах чадвартай байх;
 - 2.6.2.6. Дүгнэлт гаргах;
 - 2.6.2.7. Зөвлөмж өгөх;
- 2.6.3. Нөхцөл байдлын шинжилгээ хийх чадвар:
 - 2.6.3.1. Байгууллагын соёл, онцлогийг ойлгох;
 - 2.6.3.2. Оролцогч талуудтай харилцаж, дүн шинжилгээ хийх;
 - 2.6.3.3. Олон талт байдлыг хүндэтгэх;
 - 2.6.3.4. Өөрчлөлтийг хүлээн авах, дасан зохицох;
 - 2.6.3.5. Үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийг зөв тодорхойлох;
 - 2.6.3.6. Өмнөх туршлага дээр үндэслэх;
- 2.6.4. Манлайлах чадвар:
 - 2.6.4.1. Манлайлах, удирдах;
 - 2.6.4.2. Үнэлгээ хийх цар хүрээг тодорхойлох;
 - 2.6.4.3. Нөөцийг үр дүнтэй удирдах, үнэлгээнд ашиглах;
 - 2.6.4.4. Багийн шийдвэрт нөлөөлөх;
 - 2.6.4.5. Зөвлөн туслах;
 - 2.6.4.6. Шийдвэр гаргах;
 - 2.6.4.7. Уян хатан байдал, анхаарал төвлөрүүлэх чадвараа харуулах;
- 2.6.7. Харилцааны ур чадвар:
 - 2.6.7.1. Харилцааны оновчтой арга, хэлбэрийг сонгох;
 - 2.6.7.2. Танилцуулга, мэдээллийг тодорхой, ойлгомжтой мэдээлэх;
 - 2.6.7.3. Үйл явдлыг логик, дэс дараалалтай илэрхийлэх;
 - 2.6.7.4. Харилцан ойлголцлыг бий болгож, зөвшилцөлд хүрэх;
 - 2.6.7.5. Зөрчилдөөнийг эв зүйгээр зохицуулах;
- 2.6.8. Хувь хүний хөгжлийн чадвар:
 - 2.6.8.1. Давуу, сул тал, боломж, эрсдэлээ тодорхойлж, өөрийгөө удирдах;
 - 2.6.8.2. Карьер хөгжлөө тодорхойлдог байх;
 - 2.6.8.3. Насан туршийн боловсрол буюу суралцахууд суралцах;

Гурав. Шинжээчид эрх олгох, сунгах, хүчингүй болгох

3.1. Шинжээчийн эрх олгох

3.1.1. Шинжээчийн эрхийг дараах үе шатаар олгоно. Үүнд:

- 3.1.1.1. Шинжээчид нэр дэвшигч нь БМИҮЗ-ээс санал болгож буй багц цагийн сургалтад хамрагдсан байна.
- 3.1.1.2. Сургалтад хамрагдсан шинжээчид нэр дэвшигч нь

сургалтын агуулгаар шалгалт өгч, 80%-аас дээш үнэлгээ авсан байна.

3.1.1.3.Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлага, 3.1.1.1, 3.1.1.2 дахь заалтыг хангасан нэр дэвшигчид Ажлын албаны захирлын шийдвэрээр шинжээчийн эрхийг 3 жилийн хугацаатай олгоно.

3.1.1.4.Ажлын албаны захирлын тушаалаар эрх авсан шинжээчийг баталгаажуулж, гэрчилгээ олгоно.

3.1.2.Шинжээч нь А, В, С зэрэглэлтэй, зэрэглэлгүй гэсэн ангилалтай байна.

3.1.2.1.А зэрэглэлийн шинжээчийн эрхийг байгууллагын магадлан итгэмжлэлд 2, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 6, багийн ахлагчаар 3-аас доошгүй удаа ажилласан, БМИУЗ-ийн үйл ажиллагаанд оролцсон байдал, ур чадвар, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр 90%-аас дээш үнэлэгдсэн;

3.1.2.2. В зэрэглэлийн шинжээчийн эрхийг байгууллагын магадлан итгэмжлэлд 1, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд ажилласан 4-өөс доошгүй, БМИУЗ-ийн үйл ажиллагаанд оролцсон байдал, ур чадвар, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр 85%-аас дээш үнэлэгдсэн;

3.1.2.3.С зэрэглэлийн шинжээчийн эрхийг байгууллагын магадлан итгэмжлэлд 1 удаа, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2 удаа ажилласан, БМИУЗ-ийн үйл ажиллагаанд оролцсон байдал, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр 80%-аас дээш үнэлэгдсэн;

3.1.2.4.Зэрэглэлгүй шинжээчийн эрхийг шинжээчийн багц цагийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан тохиолдолд тус тус олгоно.

3.1.3. Шинжээчийн эрхийг дараах тохиолдолд шууд олгоно.

3.1.3.1.Боловсролын магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөлийн гишүүнд;

3.1.3.2.БМИУЗ-ээс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан, ажиллаж байсан удирдах ажилтанд “Зөвлөх шинжээч”;

3.1.3.3.Тус байгууллагад 5-аас дээш жил ажилласан, туршлагатай ажилтанд шинжээчийн эрхийг шууд олгон, ажиллуулж болно.

3.2.Шинжээчийг дараах байдлаар сонгон ажиллуулна. Үүнд:

3.2.1.Мэдээллийн санд бүртгэлтэй, эрх бүхий шинжээчдээс сонгоно.

3.2.2.Тухайн сонгосон шинжээчийг жилд 3-аас дээшгүй удаа ажиллуулна.

3.2.3.Багийн ахлагч нь А эсвэл В зэрэглэлтэй шинжээч байна.

3.3.Шинжээчийн эрхийг дараах тохиолдолд сунгана. Үүнд:

3.3.1.Шинжээчээр 3 жил ажилласан байх;

3.3.2.Шинжээчийн эрхээ сунгуулах хүсэлт (өргөдөл)-ийг бичгээр ирүүлэх;

3.3.3.Баталсан загварын дагуу шинжээчээр ажилласан тухай тайланг боловсруулж, Ажлын албанд ирүүлсэн байх;

3.3.4.БМИУЗ-ийн Ажлын албанаас журмын 3.3.2, 3.3.3 дахь заалт, холбогдох мэдээллийг үндэслэн, эрх сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

3.3.5.Сүүлийн 2 жилийн хугацаанд сургалтын байгууллага, хөтөлбөрт шинжээчээр ажиллаагүй тохиолдолд сургалтад дахин хамрагдсаны дараа шинжээчийн эрхийг нь сунгана.

3.4.Шинжээчийн эрхийг дараах тохиолдолд хүчингүй болгоно.

3.4.1.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргасан;

3.4.2.Хууль тогтоомж, дүрэм, журам болон ёс зүйн шаардлагыг зөрчсөн нь нотлогдсон;

3.4.3.Шинжээчийн эрхийн хүчинтэй хугацаа дууссан ч сунгах хүсэлт, тайланг хугацаанд нь ирүүлээгүй;

3.5.Ажлын албаны мэдээллийн технологи, хүний нөөц хариуцсан ажилтнууд шинжээчийн мэдээллийн санг бүрдүүлж ажиллана.

Дөрөв. Хариуцлага, хяналт шинжилгээ

4.1.Шинжээч ёс зүйн шаардлагыг зөрчсөн нь нотлогдсон бол холбогдох эрх зүйн хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

4.2.Энэ журмын хэрэгжилтийг байгууллагын чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан ажилтан хянаж, дүн шинжилгээ хийж ажиллана.

--oo0oo--